

ӨМНӨД СОЛОНГОСЫН СОНИН-СЭТГҮҮЛИЙН
ТОМООХОН КОНЦЕРНУУД

Ч.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: мэдээллийн салбар, дагуул хэвлэл, медиакомпани, чебола, сонин-сэтгүүлийн концерн, цахим сонин.

Япон Дэлхийн хоёрдугаар дайнд ялагдаж, Солонгосын хойгийн өмнөд хэсэгт тусгаар улс байгуулагдсан нь мэдээллийн салбарт хувь хүн бизнес эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлжээ. «Дон-А Илбо» («Дон-А-гийн цоморлог»), «Чо-сень илбо» («Солонгосын өдрийн мэдээ») зэрэг сонин дагуул хэвлэлүүдтэй болж, эзэд нь яваандаа магнат буюу медиабарон болсон байна.

1990-ээд оны үед Өмнөд Солонгос ардчиллын замаар тууштай замнахад хэвлэлийн, өргөн нэвтрүүлгийн, реклам болон ОНМХ-ийн үйл ажиллагаатай холбоотой бусад чиглэлийн компаниудын бүхэл бүтэн тогтолцоо бий болжээ. 2001 он гэхэд эдгээр медиакомпанийн тоо 236-д хүрсэн байна. Хамгийн томоохон медиакомпаниуд өөрийн аудиторид бүх талын үйлчилгээ

үзүүлдэг. Учир нь тэд сониноос гадна сэтгүүл, мөн радио- ба телесувагтай байдаг.

Медиакомпаниуд анхандаа хувьцаат нийгэмлэг байсан тул аж үйлдвэр, санхүүгийн бүлэглэлийн эздийн сонирхлыг татсан юм. Улмаар сонинуудын хувьцааны нэлээд хэсэг нь чебола хэмээх томоохон аж үйлдвэр, пүүсийн эздийн гарт орсон байна. 1990-ээд оны дунд үе гэхэд Сөүлийн «Жүнань илбо» бүлэгт хамаарах хэвлэлүүдийн дийлэнх хэсгийг (68%) «Самсунг» концерн эзэмшиж байсан бол «Мүнххуа илбо» («Мүнххуагийн өдрийн мэдээ») компанийн хувьцааны 99% нь автомашин үйлдвэрлэдэг «Хөндэ» пүүс, «Гёнхян шиньмүн» («Гёнханы сонин») сонины хувьцааны мөн 99% нь химийн ба тэсрэх бодис үйлдвэрлэдэг «Ханьхуа» бүлэглэлийн мэдэлд байв. Ийн медиакомпаниуд аж үйлдвэрийн пүүсүүдтэй нягт холбогдсоныг зарим сонин буруушааж, шүүмжилж байлаа. Тухайлбал, «Самсунг»-тай ажил хэргийн холбоо-

той байдаг «Жүнань илбо» («Жүнанийн өдрийн мэдээ») -г шүүмжилсэн хэд хэдэн өгүүллийг «Чосень илбо» сонины удирдлага 1996 онд нийтэлжээ. «Чосень илбо»-гийн ерөнхий редактор: «Бид чухам "Жүнань илбо"-г буруушаагаагүй. Гагцхүү чеболатай холбоотой байгааг нь л эсэргүүцэж байна. Сонины бизнесээс "Самсунг" явах ёстой» гэж байр сууриа илэрхийлсэн байдаг. «Дон-А илбо» ч энэ байр суурийг дэмжиж, сонин хэвлэл нь чебола нарын эрх ашгийг хамгаалдаг бамбай байх ёсгүй гэж үздэгээ мэдэгджээ¹.

1997 онд эдийн засгийн хямрал дэгдсэн нь сэтгүүл зүйг чебола нараас чөлөөлөх таатай нөхцлийг бүрдүүлсэн юм. Санхүүгийн алдагдалд орсон, зээлээ эргүүлэн төлж чадахгүй болсон зарим пүүс, компани сонины бизнест оролцохоо зогсоож байгаагаа албан ёсоор зарлахад хүрчээ. Тухайлбал, «Ханьхуа», «Хөндэ» корпораци хэд хэдэн сонин, сэтгүүлчдийн байгууллагын удаа дараагийн шаардлагад буулт хийн энэ тухай 1998 оны 1-р сард мэдэгдсэн байна. Чөлөөлөгдсөн хувьцаануудыг «Гёнхян шиньмүн», «Мүнхуа илбо» сонины

удирдлага, сэтгүүлчдэд хуваарилжээ. «Самсунг»-ийн хувьд гэвэл тус концерн 1999 оны 3-р сард «Жүнань илбо»-той хамтран ажиллахаа зогсоож буйгаа мэдэгдсэн юм.

Сонины томоохон компаниуд нь чебола нараас хамааралд орохыг зарчмын хувьд буруу гэж үздэг бөгөөд санхүүгийн хүндрэл, бэрхшээлийг да-

ван туулахад туслах янз бүрийн арга хайдаг. «Чосень илбо», «Дон-А илбо», «Ханьгүг илбо» («Солонгосын өдрийн мэдээ») олсон орлогоороо өндөр ашигтай үл хөдлөх хөрөнгө худалдах авах, сэтгүүл зүйтэй огт холбогдолгүй тэс өөр салбар дахь бизнест оролц-

дог. Тухайлбал, «Чосень илбо», «Ханьгүг илбо» өөрсдийн зочид буудлуудтай бөгөөд үүнээс чамгүй ашиг олдог байна.

Медиакомпанидын үнэмлэхүй олонх нь одоо хувь хүмүүсийн гарт нэгэнт шилжжээ. Үлдсэн цөөн хэд нь онцгой статустай. 2003 онд хаагдсан «Сөүл шиньмүн» («Сөүлийн сонин») сонин олон жилийн турш засгийн газрын хэвлэл гэгдэж байв. Түүний орон зайг «Кореа шиньмүн» («Солонгосын сонин») эзэлжээ. Мөн шашны байгууллагуудаас эрхлэн гаргадаг хэвлэлүүд

«

Медиабүлгүүд хэвлэлийн зах зээлийн бүхий л салбарыг хамрахыг зорьдог. Өмнөд Солонгосын сонин-сэтгүүлийн томоохон концерн нь хэвлэлийн бизнесийн суурь нь болсон өдөр тутмын нөлөөтэй сонин (үндэсний хэмжээний), зугаа цэнгээний спортын таблоид сонин, долоо хоног тутмын нямдуг сонин, сар тутмын зузаан сэтгүүл, мөн тодорхой асуудалд зориулагдсан хэдэн сонин, сэтгүүл эрхлэн гаргадаг.

»

бий. Эдгээрээс хамгийн нэртэй нь «Гүмнинь» протестант сүмийн хэвлэлийн бүлгээс эрхлэн гаргадаг «Гүмнинь дэйли» (1988 онд байгуулагдсан), «Файнэншл ньюз» (2000 он), «Спортс түдэй» (1999 он), мөн Мүн Сан Мений Нэгдлэгийн сүмээс эрхлэн гаргадаг «Сегие илбо» (1989 он) юм. Түүнчлэн тун өвөрмөц статустай «Хангёрье шиньмүн» сониныг (1988 он) дурдах хэрэгтэй. Энэ сонин редакцид нь ажилладаг сэтгүүлчид, хувьцаа эзэмшигч хэдэн арван мянган хувь хүний эзэмшил юм.

Өмнөд Солонгост үйл ажиллагаагаа явуулж буй медиакомпаниуд дотор манлайлагч байр суурийг «их гурвал» гэгддэг «Чосён илбо», «Жүнаны илбо», «Дон-А илбо» эзэлдэг. Эдгээр бүлэглэлүүдээс эрхлэн гаргаж байгаа сонинууд орчин үеийн Өмнөд Солонгосын тогтмол хэвлэлийг нүүр царайг тодорхойлдог бөгөөд хэвлэгдэх хувь, уншигчдын тоо, нийтлэлийн чанар зэрэг үзүүлэлтээрээ бусдаасаа хол тасархай учир олон нийтийн хувьд төдийгүй, бизнесийн элит, түшмэдийн хувьд мэдээллийн, задлан шинжлэлт материалын чухал эх сурвалж болдог.

Медиабүлгүүд хэвлэлийн зах зээлийн бүхий л салбарыг хамрахыг зорьдог. Ерөнхийдөө Өмнөд Солонгосын сонин-сэтгүүлийн томоохон концерн нь хэвлэлийн бизнесийн суурь нь болсон өдөр тутмын нөлөөтэй сонин (үндэсний

хэмжээний), зугаа цэнгээний спортын таблоид сонин, долоо хоног тутмын нимгэн сонин, сар тутмын зузаан сэтгүүл, мөн тодорхой асуудалд зориулагдсан хэдэн сонин, сэтгүүл эрхлэн гаргадаг. Тухайлбал, «Чосён илбо» медиабүлгээс: а) үндэсний хэмжээний өдөр тутмын сонин «Чосён илбо», б) спортын «Сыпочи Чосён» («Чосёний спорт») сонин, в) нийгэм-улс төрийн долоо хоног тутмын «Жү-гань Чосён» («Долоо хоногийн Чосён») сонин, г) сар тутмын зузаан сэтгүүл «Вольгань Чосён» («Сар тутмын Чосён»), д) бусад хэвлэлийг (хүүхдийн өдөр тутмын «Сонён Чосён илбо»/«Чосёний хүүхдийн өдрийн мэдээ» сонин, загас барих хоббитой хүмүүст зориулагдсан «Вольгань нагг-ши»/«Загасчлалын сар тутмын сэтгүүл» сэтгүүл г. м.) эрхлэн гаргаж байна.

Ер нь том концерн гэлтгүй, жижиг бүлгүүд ч энэ жишгийг дагахыг хичээдэг.

«Чосён илбо» (www.chosun.com)

1920 онд үндэслэгдсэн «Чосён илбо» япончуудын дарлал, цэргийн дэглэмүүд, ардчилсан нийгэм гээд түүхийн ямар ч үед нөлөө бүхий хэвлэл байсан юм. Сониныг эрхлэн гаргагчдын хэлснээр, «Чосён илбо» Солонгосын орчин үеийн түүхийн гэрч, он тооллын бичээч мөн. Японы түрэмгийллийн үед тус сонин редакцийнхаа бодлогын үндэс болсон дөрвөн зарчмыг тунхагла-

сан бөгөөд түүндээ одоо ч үнэнч хэвээр байна².

«Чосень илбо»-гийн түүх бол Өмнөд Солонгосын сэтгүүл зүйн түүх гэсэн яриа байдаг. Үүнийг судлаачид хоосон хийрхэл, хэтрүүлэл биш гэж үздэг³. Тус сонин олон зүйл дээр анхдагч, манлайлагч байсаар иржээ. 1979 оны 3-р сард «Чосень илбо»-гийн хэвлэгдэх хувь Солонгосын сэтгүүл зүйн түүхэнд анх удаа 1 саяын босгыг давжээ. 1992 онд тус сонины хэвлэгдэх хувь 2 сая, 2002 онд 2,64 саяд хүрсэн байна. Редакцийн гаргасан тооцоогоор, «Чосень илбо»-г нийт өрхийн 18,7% уншдаг. Сонины түгээлт, борлуулалтыг Өмнөд Солонгост 1731, гадаадад 24 пүүс хариуцаж байна.

«Чосень илбо» бол зөвхөн дотооддоо төдийгүй, хилийн чанадад ч хүлээн зөвшөөрөгдсөн хэвлэл юм. 2000 оны 7-р сард Америкийн долоо хоног тутмын «Эдитор энд паблишер» сэтгүүл дэлхийн хамгийн том 100 сонины жагсаалтыг гаргахдаа «Чосень илбо»-г 10-т байрлуулсан байдаг.

Сонины редакцид 785 хүн ажилладаг бөгөөд тэд дугаарыг шуурхай, мэргэжлийн болон техникийн өндөр төвшинд хэвлэн гаргахад гар бие оролцдог. И Кью-тай, Ким Дэ Жүн (ерөнхийлөгчийн амидаа), Ю Күн-ил, Хон Са-жүн нарын тоймч, сурвалжлагчид нэг бус удаа дотоодын ба олон улсын сэтгүүлчийн байгууллагын нэр хүнд бүхий шагналыг гардан авч

байжээ. Редакци эдийн засаг, улс төрийн сэдвээрх мэдээллийн, задлан шинжилсэн материалуудад түлхүү ач холбогдол өгдөг. «Чосень илбо» улс орон даяар тархсан мэдээллийн товчоо, салбаруудтай. Мэдээллийн гурван товчоо (Пусан, Тэгүд Ённам, Гуаньжүд Хонам, Иньчоньд Кеньин) «Чосень илбо» ба компаниас эрхлэн гаргадаг бусад сонинд зориулж мэдээлэл цуглуулж байдаг. Түүнээс гадна Пусан, Тэгү, Иньчонь, Гуаньжү, Тэжон, Сүвон, Чөжү зэрэг орон нутгийн 11 томоохон хотод «Чосень илбо»-гийн салбарууд ажилладаг.

Үндэсний хэмжээний бусад сонины адил «Чосень илбо» олон улсын мэдээлэлд төдийлөн ач холбогдол өгдөггүй. Учир нь гадаад үйл явдлын тухай мэдээллийг уншигчдын өчүүхэн хэсэг сонирхдог гэж үздэг (1993 онд олон нийтийн санал бодлыг судлахад уншигчдын ердөө 1% олон улсын мэдээллийг сонирхдог болох нь тогтоогджээ). Гэвч энэ сэдвийг хамгийн туршлагатай, хашир сэтгүүлчид тусгадаг байна. «Чосень илбо»-гийн сурвалжлагчид Япон, Хятад, Гонконг, АНУ (Вашингтон, Нью-Йорк), Франц (Парис), Герман (Бонн), ОХУ-д (Москва) сууж байна.

Өнөөдрийн «Чосень илбо» бол үйлдвэрлэлийн явц нь бүрэн компьютержсэн орчин үеийн хэвлэл юм. Компанид ажилладаг компьютерийн мэргэжилтнүүд өгүүлэл бичих, редак-

торлах, макетлах, хэвлэх, түгээх зэрэг хамгийн эрс тэс өөр үүрэг гүйцэтгэж чаддаг онлайн гайхамшигтай программ бүтээсэн байна. «ЧОРУС» («CHORUS») гэж нэрлэгдсэн энэ программ Интернеттэй холбогдсон бөгөөд сэтгүүлчдэд материал бэлдэх дамжлага, шат бүрт нь туслалцаа үзүүлэх чадвартай.

Компьютерийн эриний хамгийн сүүлийн үеийн ололт амжилттай хамсах зорилгоор «Чосень илбо» 1995 оны 10-р сард «Дижитэл Чосень» («Digital Chosun») хэмээх цахим сонин үндэслэсэн байна. Улс орны болон хилийн чанадын нийгэм-улс төрийн амьдралын хамгийн тулгамдсан асуудлуудаар чанарын өндөр төвшинд бичигдсэн мэдээллийн, задлан шинжилгээт олон материалыг эндээс уншиж болно. Сургуулийн өмнөх ба сургуулийн насны хүүхдүүдийг компьютер, Интернеттэй танилцуулснаар тэднийг XXI зууны техникийн дэвшлийн өндөр төвшинд бэлтгэх зорилготой «KidNet» («Багачуудад зориулсан сүлжээ») хэмээн өргөн хэмжээний кампанит ажлыг хэдэн сарын дараа буюу 1996 оны 3-р сард «Чосень илбо» санаачилж эхлүүлжээ⁴. Үүний үр дүнд зуу зуун мянган хүүхэд компьютертэй харьцаж, Интернет ба бусад онлайн сүлжээнд холбогдож сурсан байна.

«Чосень илбо» бол Өмнөд Солонгосын медиакомпанийн суурь хэвлэл

юм. Тус сониныг 1933 онд бизнесмен Бан Үн-мо худалдан авснаасаа хойш хэвлэлийн бүлэглэл байгуулж эхэлжээ. 1935 онд «Чо Гван» сонин, 1936 онд «Ёсөн» эмэгтэйчүүдийн сэтгүүл, 1937 онд «Сонён Чосён илбо» хүүхдийн өдөр тутмын сонин, «Сонён» хүүхдийн сэтгүүл гарч эхэлсэн байна. 1939 онд «Чосён илбо» орон нутгийн мэдээллийн хавсралттай болж, Солонгосын 8 хотод хэвлэгдэх болсноор зөвхөн нийслэлийн бус, үндэсний хэмжээний сонин болжээ. Гэвч 1940 онд Японы колонийн засаг захиргаанаас шаардсанаар Бан Үн-мо сонин, сэтгүүлүүдээ хаахаас өөр аргагүй болсон юм. 1945 онд Япон Дэлхийн хоёрдугаар дайнд ялагдсанаа хүлээн зөвшөөрснөөр Бан Үн-мо хэвлэлүүдээ сэргээж эхэлжээ.

Өнөөдөр энэ медиакомпаниас өдөр тутмын гурван сонин («Чосён илбо», «Сонён Чосён илбо», 1990 онд үндэслэгдсэн «Спортс Чосён»), долоо хоног тутмын нэг сонин (1968 онд үндэслэгдсэн «Жү-гань Чосён»), сар тутмын дөрвөн сэтгүүл («Вольгань сань», 1970; «Вольгань Чосён», 1980; «Вольгань нагг-ши», 1984; эмэгтэйчүүдэд зориулсан «Фил», 1993) эрхлэн гаргаж байна. Хэвлэл бүр өөр өөрийн зорилгот аудиторитой бөгөөд өвөрмөц онцлогтой. Тухайлбал, «Сонён Чосён илбо» багачуудад өгөөжтэй мэдээлэл хүргэж, тэдний мэдэх хүсэл сонирхлыг өдөөх зорилготой бол «Жү-гань Чосён» үйл явдлуудад ул суурьтай,

гүн гүнзгий задлан шинжилгээ хийдэг, «Вольгань Чосень» нийгмийн санаа сэтгэлийг зовоож буй асуудлуудыг дэвшүүлэн гаргадаг. Мөн «Вольгань сань» уулын аяллыг сонирхогчдод, «Вольгань нагг-ши» загас барих хорхойтой хүмүүст зориулагдсан байдаг.

«Чосень» бүлэг Бан гэр бүлийн эзэмшил юм. Тэд нийт хувьцааны 76%-ийг эзэмшдэг бөгөөд удирдах албан тушаалуудад ажилладаг. Концерны зөвлөлийн даргаар Бан Вү-юн, ерөнхийлөгчөөр Бан Сан-хун, удирдах захирлаар Бан Кье-сүн ажилладаг байна. «Чосень» бүлгийн сонин, сэтгүүлүүд, тэдгээрийн салбар, хэлтсүүдийн захирал, эрхлэгчээр Бан гэр бүлд үнэнч, тэдэнтэй үзэл бодол нэгтэй хүмүүс томилогддог. «Чосень илбо» ба бусад сонин, сэтгүүл барууны чиглэлийн консерватив хэвлэлд тооцогддог. Эдгээр хэвлэл Ардчилсан Солонгостой харилцаагаа сайжруулахыг эрс буруушааж, улайран тэмцдэг байна.

Шинэ зуунд «Чосень» бүлгээс тавьж буй зорилго тодорхой. Медиакомпанийн удирдлага энэ тухай: «Бид хэвлэмэл ба цахим мэдээллийн хэрэгслийн хоорондох зааг, ялгааг үгүй хийж, ОНМХ-ийн нэг мөр болсон загвар бүтээхийг зорьж байна. XXI зуунд манай медиа бүлэг сонин, сэтгүүл, радио, телевизийг хослуулж, мэдээллийн хувьсгалыг манлайлах болно»⁵ гэж мэдэгдсэн байдаг.

«Дон-А илбо» (www.donga.com)

2000 оны 4-р сард 80 жилийнхээ ойг тэмдэглэсэн «Дон-А илбо» Сөүлийн төвд баригдсан 21 давхар шилэн шинэ байшинд оржээ. Ингэснээрээ сонины удирдлага нийгмийг ил тод байлгах, өөрөө ч ил тод байхаа илэрхийлсэн юм. Шинэ байшинд медиакомпаниас гаргадаг бүх сонин, сэтгүүл, мөн «Дон-А илбо»-гийн эздийн санаачилсан Солонгосын хэвлэлийн музей нүүн оржээ.

«Дон-А илбо» 1920 онд «Чосень илбо»-той бараг нэг зэрэг гарах болсон юм. Энэ хоёр сонин хоёулаа Японы дарлалыг эсэргүүцэж, цэргийн дэглэмүүдийн үед хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэж, ардчилсан нийгмийг цогцлоон байгуулахын төлөө дуу хоолойгоо өргөж байсан бөгөөд Өмнөд Солонгосын хэвлэлийн төдийгүй, сэтгүүл зүйн нүүр царай, өнгө төрхийг тодорхойлогч нь байсаар иржээ. Гэвч энэ хоёр сонин өөр өөрийн хувь заяа, байр суурь, ертөнцийг үзэх үзэлтэй байсан ба өнгөрөгч 80 гаруй жилийн хугацаанд өөр хоорондоо нэг ч өдөр алгасалгүй өрсөлдсөөр өнөөг хүрсэн байна. Энэхүү өрсөлдөөн аль эрт сонины нүүрнээс хальж, олон нийтийг хамарсан соёлын арга хэмжээ, спорт, урлагийн наадам, үзэсгэлэн, тэмцээн зохион байгуулж байв. Эдгээр арга хэмжээ сонины нэр хүндийг хэр өсгөсөн нь тодорхойгүй ч нэлээд урт хугацааны турш «Дон-А илбо» өрсөлдөгчөөсөө ялимгүй илүү байсан юм.

Дайны дараах жилүүдэд «Дон-А илбо» аажмаар тэргүүлэгч байр сууриа алдаж, сүүлдээ «Чосөн илбо»-гоос хоцорчээ. Үүнийг дараах баримтаас харж болно. 2001 онд «Дон-А илбо» 2,2 сая хувиар түгэж байсан нь өрсөлдөгчөөсөө 0,4 саяар дутуу байв. Гэвч медиакомпанийн удирдлага гэрэлт ирээдүйд итгэж байгаа бөгөөд ойрын жилүүдэд өдөр тутмын хэвлэлийн манлайлагч болно гэж үздэг. Медиа бүлгийн ерөнхийлөгч Ким Бьон-кван энэ талаар: «"Дон-А илбо" бол БНСУ дахь хамгийн зоригтой, шударга, нөлөө бүхий хэвлэл мөн. Манай сонин одоо ч ард түмэн, ардчилал, соёлоо дээдэлсэн компанийнхаа

урианд үнэнч байгаа»⁶ гэж ярьжээ. Ингэж үзэх ч үндэслэл бий. 1995 онд долоо хоног тутмын «Медиа түдэй» сонин Сөүлийн сэтгүүл зүйн сургуулиудын 160 профессорын дунд санал асуулга явуулахад «Дон-А илбо» шилдэг сониноор шалгарсан байна⁷.

«Дон-А илбо»-г Өмнөд Солонгост төдийгүй, дэлхий дахинаа хүлээн зөвшөөрчээ. 1970-аад оноос эхлэн олон улсын янз бүрийн байгууллага тус сонинд удаа дараа хүндтэй шагнал

гардуулж, эрхлэн гаргагчдыг нь гишүүнээрээ сонгож байсан юм. Тухайлбал, 1974 онд АНУ-ын алдарт «Фридом хауз» хүрээлэн хэвлэлийн эрх чөлөөний төлөө олон жил уйгагүй тэмцсэнийг нь үнэлэн тусгай шагнал гардуулсан бол 1985 онд Миссуригийн сэтгүүл зүйн сургууль «Дон-А илбо»-г Азийн шилдэг сонин гэж үнэлэн «Сэтгүүл зүйд

үнэнчээр зүтгэсний төлөө» шагналаа гардуулжээ (дашрамд хэлэхэд, энэ нь Азийн сонин уг шагналыг авсан гурав дахь тохиолдол бөгөөд 1936 онд Японы «Асахи симбүн», 1941 онд Гонконгийн «Дагун Бао» шагнагджээ). Түүнчлэн «Дон-А илбо»-гийн хүндэт ерөнхийлөгч Ким

«

«Дон-А илбо»-г Өмнөд Солонгост төдийгүй, дэлхий дахинаа хүлээн зөвшөөрчээ. 1970-аад оноос эхлэн олон улсын янз бүрийн байгууллага тус сонинд удаа дараа хүндтэй шагнал гардуулсан юм. Тухайлбал, 1974 онд АНУ-ын алдарт «Фридом хауз» хүрээлэн хэвлэлийн эрх чөлөөний төлөө олон жил уйгагүй тэмцсэнийг нь үнэлэн тусгай шагнал гардуулсан бол 1985 онд Миссуригийн сэтгүүл зүйн сургууль Азийн шилдэг сонин гэж үнэлжээ.

»

Сан-маныг Азийн сонины сангийн даргаар (1976 он), Олон улсын хэвлэлийн хүрээлэнгийн зөвлөлийн гишүүнээр (1978 он) тус тус сонгож, Олон улсын сонины редакторуудын холбоо «Эрх чөлөөний алтан өд»-өөр шагнаж (1982 он) байжээ.

«Дон-А илбо» гадаад зах зээл дээр гарснаар хилийн чанадад амьдарч, аж төрж буй солонгосчуудад шуурхай мэдээлэл хүргэхийг чухалчилсан байна. Тус сонин АНУ (Чикаго, Филадельфи),

Австрали (Сидней), Бразилд (Сан-Паулу, Квито) салбартай бөгөөд тэндээ хэвлэгдээд дэлхийн томоохон хотуудаар түгдэг. Харин тусгай сурвалжлагчид нь Вашингтон, Токио, Парис, Москва, Бээжинд сууж байна.

Гэхдээ «Дон-А илбо»-гийн сурвалжлагчид гол анхаарлаа дотоодын үйл явдлыг тусгахад хандуулдаг. Улс орон даяар мэдээллийн товчоо, сурвалжлагчдын цэгүүдийн сүлжээ байгуулагдаж, түгээлтийг 1355 нэгж хариуцаж байна. Пусан, Тэгү, Гуаньжү, Ансан, Чезү зэрэг томоохон хотуудад «Дон-А илбо»-гийн салбар редакциуд, хэвлэх үйлдвэрүүд байрладаг. Үүн дээр Сөүлийн гурван хэвлэх үйлдвэр нэмэгдэх бөгөөд чухам ингэж байж л 2 сая гаруй хувийг цаг тухайд нь хэвлэж, түгээдэг ажээ.

1990-ээд оны 2-р хагаст «Дон-А илбо» мэдээлэл-үйлдвэрлэлийнхээ тогтолцоог цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилжээ. Орчин үеийн технологи, компьютерийн сүлжээг ашиглан мэдээлэл цуглуулах, материал бичихээс авахуулаад хэвлэх хүртэлх бүхий л шат дамжлагыг сэтгүүлчид гүйцэтгэдэг.

«Дон-А илбо» сонин медиа бүлэг болж өргөжих эхлэл 1930-аад оны эхэнд тавигджээ. 1931 оны 11-р сард сар тутмын «Шинь Дон-А» («Шинэ Дон-А») сэтгүүл, 1933 оны 1-р сард эмэгтэйчүүдэд зориулсан сар тутмын «Шинь

гажон» («Шинэ гэр бүл») сэтгүүл гарах болсон байна. Гэвч аль аль нь удаан оршин тогтноогүй бөгөөд эхнийх нь Японы засаг захиргааны шаардлагаар, удаах нь санхүүгийн хүндрэлээс болж 1936 оны 8-р сард хаагджээ. «Дон-А илбо»-г эрхлэн гаргагчид үүнтэй эвлэрээгүй бөгөөд 1937 онд хүүхэд, залуучуудад зориулсан өдөр тутмын «Сонён Дон-А илбо»-г гаргах болов. Богино хугацаанд уншигч олны талархлыг хүлээсэн шинэ сонин «Дон-А илбо»-гийн хамтаар 1940 онд япончуудын шахалтаар хаагдсан юм. Хэрэв «Дон-А илбо» дайн дууссаны дараахан буюу 1945 оны 12-р сард гаралтаа сэргээсэн бол «Сонён Дон-А илбо» гагцхүү 1964 онд л уншигчидтайгаа дахин золгожээ. Мөн онд «Шинь Дон-А» сэтгүүл, 1967 онд «Шинь гажон» «Ёсен Дон-А» нэрээр гарч эхэлсэн байна.

Дараа дараагийн жилүүдэд медиа бүлэг шинэ шинэ хэвлэлээр баяжжээ. Тухайлбал, өнгөрөгч оны үндэсний ба олон улсын хэмжээний гол үйл явдлуудыг тоймлодог жил тутмын «Альманах Дон-А» (1967 он), шинжлэх ухааны асуудлуудад зориулагдсан сар тутмын «Гуа-хаг Дон-А» (1986 он), болж өнгөрсөн үйл явдлуудыг гүн гүнзгий задлан шинжилдэг долоо хоног тутмын «Жүгань Дон-А», шинэ үеийнхэнд зориулагдсан долоо хоног тутмын «Летс» (1992 он) өөрийн гэсэн хүрээний уншигчидтай болсон байна.

«Дон-А илбо» «Чосөн илбо»-гийн нэг адил гэр бүлийн бизнес юм. Тус сониныг үүссэн цагаас нь хойш Ким гэр бүлийнхэн эзэмшиж байна. Сониныг үндэслэгч Ким Сүн-сү (1891-1955) Солонгосын сэтгүүл зүйд тод ул мөр үлдээсэн, соёл, улс төрийн гарамгай зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч байв. Тэрээр зөвхөн хэвлэлийн эрх чөлөөний төлөө төдийгүй, эх орныхоо тусгаар тогтнолын төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр тэмцэж байжээ. Түүний амьдрал, тэмцэл судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсан бөгөөд солонгос, англи хэлээр хэд хэдэн бүтээл гарсан юм. Ким Сүн-сүг амьд ахуйд нь гэр бүлийнх нь гишүүд медиа бүлгийг удирдах ажилд оролцох болжээ. Одоогийн тэргүүн 70 настай Ким Бьон-кван сонины редакцийн хаалгыг 1968 онд татсанаас хойш амьдрал, уран бүтээлээ «Дон-А илбо»-той холбож, албан тушаал ахисаар 1993 онд медиа бүлгийн даргаар сонгогдсон байна.

«Чосөн илбо»-г бодвол «Дон-А илбо» ерөнхийлөгч Ким Дэ Жүний Хойд Солонгостой харилцаагаа сайжруулах «нарны илчийн бодлого» гэгчийг сайшаан дэмждэг. Төр засагтай хурцадмал харьцаатай байдаг тус сонинд хар буруу санагч олон. Гэсэн хэдий ч «Дон-А илбо» «Уншигч маань мэдэхийг хүсч байгаа тэр зүйлийн тухай бичих, мэдээлэхэд бидэнд илд ч, буу ч, өөр ямар ч аюул саад хийж чадахгүй»⁸ хэмээх зарчимдаа үнэнч хэвээр байна.

«Жүнань илбо» (www.join.com)

«Их гурвал»-аас хамгийн залуу нь «Жүнань илбо» юм. 1965 онд анхны дугаараа уншигчдын гар дээр тавьсан тус сонин нөлөө бүхий хэвлэлүүдтэй амжилттай өрсөлдсөөр 1978 оны сүүлээр 1 сая, 1995 онд 2 сая, 2000 он 2,4 сая хувиар хэвлэгдэх болжээ. 1999 онд Дэлхийн сонины холбооны жил тутмын товхимол «Уорлд пресс трендс» «Жүнань илбо»-г Өмнөд Солонгосын хамгийн том сониноор шалгаруулсан байдаг (тус сониныг 4 сая 198 мянган хүн уншдаг гэж товхимолд дурджээ). Сонины эзэд үүнийг тайлбарлаж: «Бид үнэн бодитой, тэнцвэртэй нийтлэлийнхээ ачаар уншигчдын итгэлийг байлдан дагуулсан юм»⁹ гэсэн байдаг.

«Жүнань илбо» Өмнөд Солонгосын сэтгүүл зүйд олон шинэлэг

зүйл сэдэж, нэвтрүүлсэн юм. Тухайлбал, 1994 онд тодорхой салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдийг орон тооны сурвалжлагчаар ажиллуулах болжээ. Тэдэнд зориулж мэргэжилтэн-сурвалжлагч гэдэг шинэ албан тушаал гаргасан байна. Мөн «Жүнань илбо»-гийн редакци Японы түрэмгийллээс уламжлагдан ирсэн босоо шрифтээс анх татгалзаж, 1995 оны 3-р сарын 20-нд Хангиль цагаан толгойн баяраар хэвтээ шрифтэд шилжжээ. Энэ нь уншилтыг илүү хялбар болгосон юм. 1998 оны 7-р сард «Жүнань илбо» онцгой чухал үйл явдлыг тусгах, мөн

эрэн сурвалжлага хийхэд тусгай бүлэг байгуулах болжээ. Ийм бүлгүүдийн ажиллагаа маш өндөр үр дүнд хүрэх болсон учир жил гаруйхны дараа зарим эрэн сурвалжлагад Кван Хуны нэрэмжит сэтгүүл зүйн нэр хүндтэй шагнал олгосон байна.

«Жүнань илбо»-гийн шинэ санаачилгуудыг бусад хэвлэл шүүрэн авчээ. «Фар Истерн экономик ревью» сэтгүүлд бичсэнчлэн: «"Жүнань илбо" Солонгосын сонин хэвлэлийг сэгсчиж, донсолгов. Харин эрхлэн гаргагч Хон Сок-хун нь тогтчихсон дүрэм журмуудыг хэмх цохиж, үргэлж ялагч болно»¹⁰.

Богино хугацаанд өөрийн хүрээний уншигчтай болж, зах зээлд байр сууриа олоход нь «Жүнань илбо»-гийн удирдлагын маркетинг, менежментын оновчтой, холыг харсан бодлого их тус болжээ. 1995 оны 4-р сард тус сонин оройн гаралтаа зогсоож, зөвхөн өглөө гарах болсон нь уншигчдынх нь тоог нэмсэн байна. Тухайн үед «Самсунг»-ийн мэдэлд байсныг «Жүнань илбо»-гийн удирдлага мөн л овжин ашиглаж, уг концерний мөнгөөр маркетингийн түрэмгий бодлого хэрэгжүүлж эхэлжээ. Радио, телевизээр сониныхоо рекламьг байнга цацаж, өрсөлдөгч хэвлэлүүдийн шилдэг сэтгүүлчдэд илүү цалин, бичлэгийн илүү өндөр шагнал амлаж өөрийн болгож байлаа. Өдөр тутмын бусад сонин ч «Жүнань илбо»-гоос дутахгүй байхыг хичээж байв.

1996 оны эхэн гэхэд «Жүнань илбо» зах зээлийн 20,7%-ийг эзэлсэн нь жинхэнэ сенсаци байлаа.

1999 оны 3-р сард «Жүнань илбо» «Самсунг»-аас тусгаар тогтножээ. Эдийн засгийн хямралын нөхцөлд, үндэсний хэмжээний томоохон корпорацис санхүүжилт авахаа байсан ч «Жүнань илбо» тэсч гарснаар барахгүй, орон тоогоо ч цомхотгоогүй байна. Гэвч мөн оны 10-р сард сонины нэр хүндэд сэв суулгасан үйл явдал болжээ. «Жүнань илбо»-гийн эрхлэн гаргагч Хон Сок-хуны эзэмшлийн татвараа төлөхөөс зайлсхийсэн «Bogwang Business Group» компанид эрүүгийн хэрэг үүсгэв. Хон Сок-хунд 3 жилийн хорих ял оноож, 3,8 тэрбум воны торгууль ногдуулсан байна. Гэвч «Жүнань илбо»-гийн уншигчид энэ таагүй явдлаас болж сониноосоо нүүрээ буруулаагүй юм.

«Жүнань илбо» сэтгүүл зүйд төдийгүй, нийгмийн амьдралын олон салбарт шинийг санаачлагч, нэвтрүүлэгч байсаар иржээ. 1990-ээд оны сүүлээр тус сонин гачигдалд нэрвэгдсэн орнуудад тусламж үзүүлэх хөдөлгөөн өрнүүлж, олон залуус сайн дураараа Руанда, Хойд Солонгос зэрэг оронд очиж ажилласан юм. Жил ирэх тусам нэмэгдэх хичээлийн ачааллыг давж гарахад сурагч, оюутнууд, тэдний эцэг эхэд туслах зорилгоор 1995 оноос эхлэн «Боловсрол ба сонин» хөтөлбөр боловсруулах болов. Мөн Өмнөд

Солонгосын их, дээд сургуулиудын рейтингийг тогтмол нийтлэх болсон нь ерөнхий боловсролын сургууль дүүргэсэн мянга мянган залууст зөв сонголт хийх, улмаар амьдралд хөлөө зөв тавихад нь ихээхэн тус болжээ.

«Жүнань илбо»-г зөвхөн Өмнөд Солонгост уншдаггүй. Тус сонины гадаад дахь анхны салбар 1974 онд Лос-Анжелест, 1976 онд Нью-Йоркд, 1979 онд Чикагод байгуулагджээ. Өдгөө «Жүнань илбо»-гийн хилийн чанад дахь сүлжээ нь хоёр төв товчоо (Вашингтон, Токио), 11 сурвалжлах төв (Парис, Берлин, Бээжин, Нью-Йорк, Гонконг), гадаад дахь 10 салбараас (АНУ-д 7, Канад, Бразил, Аргентинд тус бүр 1) бүрдэж байна.

Хоёр гол өрсөлдөгчөө бодвол «Жүнань илбо» медиа бүлгийнхээ анхдагч байсангүй.

Тус сониныг эрхлэн гаргагч «Жүнань илбо инкорпорейтед» медиа бүлгийн эхлэл 1963 оны 6-р сард «Дон-Ян бродкастинг» (Ти-би-си) радиостанци байгуулагдсанаар тавигджээ. Үүний дараа Ти-би-си телестуди, 1965 оны 3-р сард «Жүнань илбо» өдөр тутмын сонин үйл ажиллагаагаа эхэлсэн юм. Энэ үеэс эхлэн «Жүнань илбо» медиа бүлгийнхээ суурь болсон байна. 1968 оноос эхлэн «Жүнань» маркийн янз бүрийн сонин, сэтгүүл («Манфли Жүнань», «Жүнань уименз», «Жүнань стьюдентз», «Жүнань тинз», г. м.) гарах болсон ч ихэнх нь өнөөдрийг хүрээгүй.

Өнөөдрийн байдлаар тус медиа бүлэг нь өдөр тутмын хоёр сонин («Жүнань илбо»-гоос гадна 1988 онд үндэслэгдсэн «Жүнань экономик дэй-ли») эрхлэн гаргадаг нэг компани, бие даасан сэтгүүлийн зургаан компаниас бүрдэж байна. Эдгээрээс хамгийн том нь болох «Жүнань Эм энд Би (magazines and books)» компани «Уименз Жүнань 21», «Стайл», «Ла Белле», «Сеси», «Кики», «Литерэри Жүнань» («Literary JoongAng») хэмээх зургаан сэтгүүл эрхлэн гаргадаг. Эхний гурав нь гэр бүлтэй эмэгтэйчүүдэд, «Сеси» гэр бүлгүй бүсгүйчүүдэд, «Кики» залууст зориулагдсан сэтгүүл юм. Түүнээс гадна тус компани аялагчдад зориулсан цуврал, лавлахууд, улс төрийн бестселлер гээд төрөл бүрийн ном хэвлэдэг.

Сонин-сэтгүүл, өргөн нэвтрүүлэг-мэдээллийн үйлдвэрлэл бүхэлдээ компьютержсэн нь «Жүнань илбо»-гийн хөгжлийг цоо шинэ шатанд гаргажээ. 1995 оны 3-р сард анхны цахим сонин «Интернет Жүнань» гарсан байна. Гурван жилийн дараа байгуулагдсан «Жүнань илбо нью медиа инкорпорейтед» (JOINS.com) охин компани Интернет болон персональ компьютерийн сүлжээгээр дамжуулан «Жүнань илбо» сонины онлайн үйлчилгээг өргөжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Ишлэл

- ¹ Far Eastern Economic Review. 12 Sept. 1996, p. 26.
- ² The Chosun Ilbo: No. 1 in Korea. Seoul, 1998, p. 3.
- ³ Круглов Е. В. Пресса Южной Кореи, с. 132.
- ⁴ The Chosun Ilbo: No. 1 in Korea, p. 31.
- ⁵ The Chosun Ilbo: No. 1 in Korea, p. 22.
- ⁶ The Dong-A Ilbo: the Korean newspaper you can trust. Seoul, 1996, p. 3.
- ⁷ Круглов Е. В. Пресса Южной Кореи, с. 141.
- ⁸ The Dong-A Ilbo Daily: A Vital Spirit of the Times, p. 8.
- ⁹ JoongAng Ilbo: the largest and most influential network in Korea. Seoul, 2000, p. 4.
- ¹⁰ Far Eastern Economic Review. 12 May 1996.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Круглов Е. В. 1993. Средства массовой информации Южной Кореи в условиях обновления и демократизации // «Вестник Московского университета», серия журналистика, № 3.
2. Круглов Е. В. 2003. СМИ Южной Кореи // Зарубежная журналистика накануне XXI века. Часть 3. М.
3. Круглов Е. В. 2005. Пресса Южной Кореи. М.
4. Круглов Е. В. 2000. Печать Восточной и Юго-Восточной Азии в условиях азиатского экономического кризиса (1997-1999 гг.) // «Вестник Московского университета», серия журналистика, № 1.
5. Ланьков А. Н. 2000. Корея: будни и праздники. М.

6. Ланьков А. Н. Печатная демократия по-корейски. // «Русский журнал». 23 окт. 2003.

7. Ли Же Хек. 1995. Особенности демократизации южнокорейской прессы в современных условиях (1987-1994 гг.). Автореф. канд. дисс. М.

8. Ткачёва Н. В. 2003. Информационные стратегии стран Восточной Азии в условиях рыночных реформ. М.

9. Chang Young-Soo. 2003. Freedom of the Press: Foundation of the News Media // Korea Focus, Seoul, № 3.

10. The History of Korean Press Movement // The 24th IFJ World Congress in Seoul. Seoul, 2001.

Резюме

В данной статье автор уделяет внимание современному состоянию крупнейших газетно-журнальных концернов Южной Кореи. Создание Южнокорейской республики после разгрома Японии во Второй мировой войне создало благоприятные условия для развития журналистики на юге полуострова. В частности, частное лицо получило право на учреждение газет и журналов. В результате бурного развития СМИ в Южной Корее уже к 2001 году в стране существовали 236 медиакомпаний. Самые крупные из них, кроме периодической прессы, имеют при себе радиостанции и телеканалы. Лидерами в сфере масс-медиа являются «Чосонь илбо», «Жунань илбо» и «Дон-А илбо», которые по-праву считаются «большой тройкой». Автор подробно останавливается на каждом из них.